



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/УЗ

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын
“Оюуны Эрин” цогцолбор сургуулийн
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 653,198.50 /зургаан зуун тавин гурван мянга нэг зуун ерэн найман төгрөг тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Багануур дүүргийн 235 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын “Оюуны Эрин” цогцолбор сургууль /Ж.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Багануур дүүргийн 235 дугаар цэцэрлэг /М.Нэргүй/-д даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий боловсролын “Оюуны Эрин” цогцолбор сургууль /Ж.Бат-Эрдэнэ/, Багануур дүүргийн 235 дугаар цэцэрлэг /М.Нэргүй/-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

15750001201

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 11 сарын
25 өдрийн 01/193 дүгээр тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын "Оюуны Эрин" цогцолбор сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк, үзүүлэлт	Ашиглалтанд орсон	Хэм нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Бусад үндсэн хөрөнгө										
1	Даралтат хөгжим	Ямаха, 220В	2014	ш	1	653,198.50	653,198.50	653,198.50	-	Багануур дүүргийн 235 дугаар цэцэрлэг
Бусад үндсэн хөрөнгийн дүн					1		653,198.50	653,198.50	-	
Нийт хөрөнгийн дүн							653,198.50	653,198.50		